



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах
улсын комиссын даргын төсвийн 2014 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн аудит*

Аудитын код: УАГ-САГ/2015/25/СТА-ТЕЗ

Улаанбаатар хот

2015 оны 4 дүгээр сар



ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДАРГЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

YAG-ын Санхүүгийн аудитын газрын
дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер:
Л.Одгэрэл
Утас:260512
Цахим хаяг:
odgerell@audit.gov.mn

Ахлах аудитор:
Ц.Цэрэнхүү
Утас:263809
Цахим хаяг:
tserenkhuuts@audit.gov.mn

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр
Бага тойруу 3
Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160
Монгол Улс

Цахим хаяг: www.audit.mn

2015 оны 4 дүгээр сар

АГУУЛГА

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /ҮАГ-САГ/2015/25/СТА-ТЕЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2015 оны 03 дугаар сарын 27-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2014 оны 04 дугаар сарын 05-наас 2014 оны 04 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд ЦАУЗБУК -ын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

ЦАУЗБУК нь үндсэн үйл ажиллагаагаа “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль”, “Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дүрэм”, “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн биелэлтийг зохион байгуулах журам”, “Нөхөн олговор олгох, түүнийг бүртгэх, тайлан гаргах журам”, санхүү, төсвийн талаарх үйл ажиллагаагаа Монгол улсын “Төсвийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” зэрэг хуулиудын хүрээнд явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын эрхэм зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгаж, нэр төрийг нь сэргээх,

тэдэнд нэг удаагийн нөхөх олговор олгох, улс төрийн хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс нь дээр дурдсан зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах чиглэлийн ажлыг хариуцан гүйцэтгэдэг. Үүнд:

- Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах ;
- Хэлмэгдэгсэд, тэдний гэр бүл, ач , зээ нарт нөхөх олговор олгох ;
- Хэлмэгдэгсдийн дурсгалыг мөнхжүүлэх, нэр төрийг сэргээх ;
- Хэлмэгдэгсэд болон нөхөн олговрын мэдээллийн нэгдсэн сан байгуулах ;

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн ерөнхийлөн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон, тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 4-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн багцын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

ЦАУЗБУК -ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн “Acolous” програмаар, санхүүгийн тайланг нэгтгэх үйл ажиллагааг “Plastic” програмаар боловсруулан гаргасан байна.

Тус газар төсвөөс санхүүждэг тул материаллаг байдлын түвшинг төсвийн урсгал зардлын санхүүжилтийн дүн 678.2 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 13.5 сая төгрөгөөр баталгаажууллаа.

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. ЦАУЗБУК-ын дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад “хэвийн” байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2014 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

2014 онд төлөвлөгөөгөөр 916.8 сая төгрөг зарцуулахаар батлагдсанаас гүйцэтгэлээр 678.2 сая төгрөг зарцуулж, 238.6 сая төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна.

Шилэн дансны тухай мэдээлэл

Тус газар нь “Шилэн дансны тухай” хуулийн дагуу өөрийн байгууллагын вэйб сайтад шилэн данс цэсийг үүсгэн, www.shilendans.gov.mn сайттай холбож, уг цэсэнд байгууллагын 2015 оны батлагдсан төсөв, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг тус тус байршуулаад байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Тайлагналын үе шатанд аудитын 4 чиглэлээр эрсдлүүдийг тогтоон, түүнд тавигдах хяналтуудыг үнэлэхэд үр нөлөөтэй байгаа тул нарийвчилсан сорилын аргаар даган мөшгих сорилыг хийлээ.

Үйлчлүүлэгчээс авсан судалгаа, тоон мэдээлэл, тайлбар, тодорхойлолт, нотлох баримтуудыг тусгайлан СТАУС програмд хадгалав.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

ЦАУЗБУК -ын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, авлага, өглөг зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.
/ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. ЦАУЗБУК-ын нарийн бичгийн даргын 2014 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 15 дугаар тушаалаар Ахмад дайчдад үзүүлэх орон сууцны дэмжлэгт зориулж батлагдсан хөрөнгөөс тус комиссын ажлын албанд ажилладаг нэр бүхий 3 ажилтанд орон сууцны дэмжлэгт нийт 30.0 сая төгрөг
2. ЦАУЗБУК-ын нарийн бичгийн даргын 2014 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 51 дугаар тушаалаар хавсралтанд дурдсан нэр бүхий 22 хэлмэгдэгсдийн хүүхдүүдэд нийт 22.0 сая төгрөг тус тус олгосон

Энэ нь “Төсвийн тухай” хуулийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” , 42.3.1-д “ Төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа

харьяалагдах ... Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх “ гэснийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, төсөвт зохицуулалт хийхдээ холбогдох зөвшөөрлийг авч байх талаар аудитын зөвлөмж, хэлмэгдэгсдийн хүүхдүүдэд нэг удаагийн буцалтгүй тусламж олгохдоо холбогдох шийдвэрийг гаргуулж, төсөвт тусгуулсны дараа олгож байх талаар албан шаардлага өглөө.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитын олон улсын стандартын дагуу аудитын явцад илрүүлсэн санхүүгийн тайланд залруулаагүй материаллаг биш аливаа алдаа, зөрчлийг тухайн байгууллагын удирдлагын анхааралд хандуулах шаардлагатай байдаг.

Дээрх шаардлагын дагуу энэ удаагийн аудитаар илэрсэн зарим алдаа зөрчлийг арилгах, цаашид дахин давтан гаргахгүй байхыг аудитын явцад үүрэг болгож, асуудлын бүртгэлд 3 асуудал тусгаж, тус газрын удирдлагад асуудлын мөрөөр холбогдох арга хэмжээ авахуулахаар зөвлөмж өгсөн болно. Зөвлөмжийг тусгайлан Менежементийн захидалд тусгасан болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

ЦАУЗБУК -ын даргын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн талаар

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 52.0 сая төгрөгийн материаллаг бус алдаа, зөрчил илэрсэн болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 1 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна. Тухайлбал: зөвлөмжийн хүрээнд мөнгөн хөрөнгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулж зардалд бичдэг, санхүүгийн үйл ажиллагааг бүрэн програмд оруулсан, тайлант онд өр, авлагын үлдэгдэлгүй тайлагнагдсан зэрэг тодорхой үр дүнд хүрсэн байна.

Зөвлөмж

Аудитаар 1 зөвлөмж өгсөн болно.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

ЦАУЗБУК –ын даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлэгдсэн байна.



**ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН
БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН
ДАРГЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол № 1

Асуудал 1

Төсвийг зориулалтын дагуу зарцуулах талаар

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг, хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

Ажиглалт

ЦАУЗБУК-ын даргын төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, тухайлбал; ЦАУЗБУК-ын нарийн бичгийн даргын 2014 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 15 дугаар тушаалаар Ахмад дайчдад үзүүлэх орон сууцны дэмжлэгт зориулж батлагдсан хөрөнгөөс тус комиссын ажлын албанд ажилладаг нэр бүхий 3 ажилтанд орон сууцны дэмжлэгт нийт 30.0 сая төгрөгийг олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь “Төсвийн тухай” хуулийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” , 42.3.1-д “ Төсвийн захирагч нь төсөвт зохицуулалт хийх саналаа харьяалагдах ... Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх “ гэснийг тус тус зөрчсөнтэй холбоотой байна.

Зөвлөмж

Цаашид батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, төсөвт зохицуулалт хийхдээ Төсвийн ерөнхийлөн захирагчаас холбогдох зөвшөөрлийг авч байх, зөвлөмжийн биелэлтийг 2015 оны 10 дугаар сард багтаан ҮАГ-т албан ёсоор гаргаж ирүүлэх;

Эрсдэлүүд

Санхүүгийн нэгтгэсэн тайлан буруу, нэгтгэгдэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Асуудлын бүртгэлийг комиссын удирдлага, санхүүгийн ажилтанд танилцуулж, баталгаажуулсан болно.



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН
ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН
КОМИССЫН ДАРГА Л.ЦОГ ТАНАА

2015. 04 24 № 783

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

Зөрчилгүй санал дүгнэлт

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
МӨНГӨН ХӨРӨНГӨ		
Кассанд байгаа бэлэн мөнгө		
Төгрөг\ ЖМС		
Банкинд байгаа бэлэн мөнгө		
Төгрөг		
Төсөвт байгууллагын харилцах		
АВЛАГА	20,253,000.00	
Бусад авлага	20,253,000.00	
31 Байгууллагаас авах авлага	20,253,000.00	
39 Бусад зардлын тооцооны авлага	20,253,000.00	
82 БАРАА МАТЕРИАЛ	12,090,308.00	10,309,220.00
88 Хангамжийн материал	12,090,308.00	10,309,220.00
89 Бичиг хэргийн материал	12,090,308.00	10,309,220.00
107 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	32,343,308.00	10,309,220.00
128 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	49,897,177.00	54,155,127.00
130 Биет хөрөнгө	46,897,177.00	41,905,127.00
137 Машин тоног төхөөрөмж(компьютер)	24,132,289.00	19,124,117.00
138 Машин тоног төхөөрөмж(компьютер) - Анхны өртөг	38,326,001.00	43,941,278.00
139 Машин тоног төхөөрөмж(компьютер) - Хуримтлагдсан элэгдэл	(14,193,712.00)	(24,817,161.00)
140 Тавилга, аж ахуйн эд хогшил	17,158,244.00	15,691,616.00
141 Тавилга, аж ахуйн эд хогшил - Анхны өртөг	26,350,289.00	26,835,012.00
142 Тавилга, аж ахуйн эд хогшил - Хуримтлагдсан элэгдэл	(9,192,045.00)	(11,143,396.00)
150 Бусад үндсэн хөрөнгө	5,606,644.00	7,089,394.00
153 Номын фонд	5,606,644.00	7,089,394.00
155 Биет бус хөрөнгө	3,000,000.00	12,250,000.00
156 Програм хангамж		12,250,000.00
157 Програм хангамж - Анхны өртөг	1,155,000.00	14,155,000.00
158 Програм хангамж - Хуримтлагдсан элэгдэл	(1,155,000.00)	(1,905,000.00)
159 Бусад биет бус хөрөнгө	3,000,000.00	
160 Бусад биет бус хөрөнгө - Анхны өртөг	3,000,000.00	
163 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	82,240,485.00	64,464,347.00
164 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
187 Өглөг		
207 Бусад өглөг		
208 Байгууллагад төлөх өглөг		
252 НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		
253 Засгийн газрын хувь оролцоо	82,240,485.00	64,464,347.00
254 Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	75,918,503.00	76,944,903.00
255 Хуримтлагдсан үр дүн	5,490,212.00	(13,312,326.00)
256 Өмнөх үеийн үр дүн	5,490,212.00	5,490,212.00
257 Тайлант үеийн үр дүн		(18,802,538.00)
259 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	831,770.00	831,770.00
263 ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	82,240,485.00	64,464,347.00
264 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	82,240,485.00	64,464,347.00

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
НИЙТ ДҮН	-	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	879,324,360.00	688,553,185.00
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	-	688,553,185.00
Улсын төвлөрсөн төсвөөс	-	688,553,185.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	688,553,185.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,897,700.00	-
Бараа, үйлчилгээний борлуулалт	25,897,700.00	-
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	25,897,700.00	-
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	25,897,700.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	905,222,060.00	688,553,185.00
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	201,143,634.35	210,643,219.00
Үндсэн болон нэмэгдэл цалин	181,245,479.80	192,504,749.00
Үндсэн цалин	162,103,236.80	164,280,110.00
Гэрээт ажилчдын цалин	14,920,076.00	20,159,813.00
Унаа хоолны хөнгөлөлт	-	8,064,826.00
Бусад нэмэгдлүүд	4,222,167.00	
Унаа, болон бусад нөхөн олговор	4,222,167.00	
Нийгмийн хамгааллын шимтгэл	19,898,154.55	18,138,470.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	16,278,176.98	14,838,064.10
Тэтгэврийн даатгалын шимтгэл	12,658,199.44	11,537,658.21
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	899,133.40	818,220.26
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,821,710.77	1,663,965.38
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	899,133.40	818,220.26
Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,619,977.54	3,300,405.89
УРСГАЛ ЗАРДАЛ	212,889,468.80	137,645,750.00
Бараа үйлчилгээний урсгал зардал	113,851,913.80	74,383,968.00
Бусад бараа үйлчилгээний зардал	113,851,913.80	74,383,968.00
Бичиг хэргийн зардал	1,514,950.00	6,937,890.00
Тээвэр, шатахуун	15,875,587.00	12,619,255.00
Шуудан, харилцаа холбоо	2,989,049.80	3,346,553.00
Дотоод албан томилолт	5,795,625.00	7,333,798.00
Гадаад албан томилолт	15,020,426.00	8,091,546.00
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	7,754,484.00	8,189,050.00
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага	388,800.00	759,860.00
Төлбөр хураамж, жижиг татварууд	2,452,024.00	568,882.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	29,304,461.00	5,800,000.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	29,304,461.00	5,800,000.00
Урсгал засвар	730,700.00	233,610.00
Гадаад зочны зардал		183,376.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	11,121,747.00	13,324,800.00
Аж ахуйн материал худалдан авах зардал	20,904,060.00	6,995,348.00
Хөтөлбөр арга хэмжээний зардал	99,037,555.00	63,261,782.00
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	99,037,555.00	63,261,782.00
Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах зардал	16,458,600.25	-
Хэлмэгдэгсэд, тэдний ар гэрт олгох нөхөн олговор	82,578,954.75	63,261,782.00
ТУСЛАМЖ, ШИЛЖҮҮЛЭГ	37,657,932.65	14,908,824.00
Засгийн газрын бусад түвшний нэгжүүдэд олгосон	37,657,932.65	14,908,824.00
Төсвийн ерөнхийлөн захирагчдад олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,657,932.65	14,908,824.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	37,657,932.65	14,908,824.00

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ	400,930,000.00	332,457,610.00
Нийгмийн халамжын зардал	400,000,000.00	277,978,500.00
Ахмад дайчдад үзүүлэх орон сууцны хөнгөлөлт	400,000,000.00	277,978,500.00
Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж	930,000.00	54,479,110.00
Мөнгөн хэлбэрээр	930,000.00	909,250.00
Нэг удаагийн тэтгэмж	930,000.00	909,250.00
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	53,569,860.00
БУСАД ЗАРДАЛ	11,647,120.00	11,700,320.00
Бусдын өмчийг ашигласны зардал	11,647,120.00	11,700,320.00
Байрны түрээс	11,647,120.00	11,700,320.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	864,268,155.80	707,355,723.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	40,953,904.20	(18,802,538.00)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	40,953,904.20	(18,802,538.00)

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	688,553,185.00
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	-	688,553,185.00
Улсын төвлөрсөн төсвөөс	-	688,553,185.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	688,553,185.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	4,533,000.00
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	-	4,533,000.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,533,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	-	693,086,185.00
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	201,131,028.35	210,643,219.00
Үндсэн болон нэмэгдэл цалин	181,245,479.80	192,504,749.00
Үндсэн цалин	162,103,236.80	164,280,110.00
Гэрээт ажилчдын цалин	10,946,876.00	18,031,613.00
Унаа хоолны хөнгөлөлт	8,195,367.00	10,193,026.00
Бусад нэмэгдлүүд	-	
Унаа, болон бусад нөхөн олговор	-	
Нийгмийн хамгааллын шимтгэл	19,885,548.55	18,138,470.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	16,267,865.30	14,838,064.10
Тэтгэврийн даатгалын шимтгэл	12,650,182.02	11,537,658.21
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	898,566.13	818,220.26
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,270,209.93	1,663,965.38
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,448,907.22	818,220.26
Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,617,683.25	3,300,405.89
УРСГАЛ ЗАРДАЛ	219,488,799.80	125,540,182.00
Бараа үйлчилгээний урсгал зардал	120,062,444.80	62,278,400.00
Бусад бараа үйлчилгээний зардал	108,415,324.80	62,278,400.00
Бичиг хэргийн зардал	1,554,200.00	3,590,350.00
Тээвэр, шатахуун	15,875,587.00	12,619,255.00
Шуудан, харилцаа холбоо	2,989,049.80	3,346,553.00
Дотоод албан томилолт	5,795,625.00	7,333,798.00
Гадаад албан томилолт	15,020,426.00	8,091,546.00
Ном, хэвлэл захиалах, худалдан авах	24,283,332.00	8,050,850.00
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага	388,800.00	759,860.00
Төлбөр хураамж, жижиг татварууд	5,861,944.00	568,882.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	36,304,461.00	5,800,000.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	36,304,461.00	5,800,000.00
Байрны түрээс	11,647,120.00	11,700,320.00
Гадаад зочны зардал		183,376.00
Урсгал засвар	730,700.00	233,610.00
Хөтөлбөр арга хэмжээний зардал	99,426,355.00	63,261,782.00
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	99,426,355.00	63,261,782.00
Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах зардал	16,458,600.25	-
Хэлмэгдэгсэд, тэдний ар гэрт олгох нөхөн олговор	82,578,954.75	63,261,782.00
ТУСЛАМЖ, ШИЛЖҮҮЛЭГ	37,657,932.65	14,908,824.00
Засгийн газрын бусад түвшний нэгжүүдэд олгосон	37,657,932.65	14,908,824.00
Төсвийн ерөнхийлөн захирагчдад олгосон санхүүжилт, шилжүүлэг	37,657,932.65	14,908,824.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	37,657,932.65	14,908,824.00
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ	400,930,000.00	332,457,610.00
Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж	930,000.00	54,479,110.00
Нэг удаагийн тэтгэмж	-	909,250.00
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	53,569,860.00

Нэг удаагийн буцалтгүй тусламж	930,000.00	-
Ахмад дайчдад үзүүлэх орон сууцны дэмжлэг	400,000,000.00	277,978,500.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	859,207,760.80	683,549,835.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(859,207,760.80)	9,536,350.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	18,146,600.00	9,536,350.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	18,146,600.00	9,536,350.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(18,146,600.00)	(9,536,350.00)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(1,030,000.80)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,030,000.80	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгсгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНЫ НИЙТ ДҮН
НИЙТ ДҮН	-	-	-	-
2012 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	75,918,503.00	831,770.00	(35,463,692.20)	41,286,580.80
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	40,953,904.20	40,953,904.20
2013 оны 3-р сарын 31-ээрх үлдэгдэл	75,918,503.00	831,770.00	5,490,212.00	82,240,485.00
2014 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	75,918,503.00	831,770.00	5,490,212.00	82,240,485.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	75,918,503.00	831,770.00	5,490,212.00	82,240,485.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(16,672,746.00)	-	-	(16,672,746.00)
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	17,699,146.00	-	-	17,699,146.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(18,802,538.00)	(18,802,538.00)
2014 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	76,944,903.00	831,770.00	(13,312,326.00)	64,464,347.00

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨСӨВ	ТАЙЛАНТ ОН	ЗӨРҮҮ	ХУВЬ
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	916,858,200.00	678,177,361.00	238,680,839.00	
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	916,858,200.00	678,177,361.00	238,680,839.00	74.0
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	916,858,200.00	678,177,361.00	238,680,839.00	74.0
Бараа, үйлчилгээний зардал	329,209,500.00	281,357,969.00	47,851,531.00	85.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	207,991,500.00	192,504,749.00	15,486,751.00	92.6
Үндсэн цалин	183,499,700.00	164,280,110.00	19,219,590.00	89.5
Гэрээт ажилчдын цалин	11,298,400.00	18,031,613.00	(6,733,213.00)	159.6
Унаа хоолны хөнгөлөлт	13,193,400.00	10,193,026.00	3,000,374.00	77.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,782,100.00	18,138,470.00	4,643,630.00	79.6
Тэтгэврийн даатгал	14,474,800.00	11,537,658.21	2,937,141.79	79.7
Тэтгэмжийн даатгал	1,663,400.00	818,220.26	845,179.74	49.2
ҮОМШӨ ний даатгал	2,067,800.00	1,663,965.38	403,834.62	80.5
Ажилгүйдлийн даатгал	413,600.00	818,220.26	(404,620.26)	197.8
Байгууллага төлөх ЭМД ийн хураамж	4,162,500.00	3,300,405.89	862,094.11	79.3
Бараа, үйлчилгээний бусад зардал	109,406,400.00	70,714,750.00	38,691,650.00	64.6
Бичиг хэрэг	3,985,500.00	3,590,350.00	395,150.00	90.1
Тээвэр (шатахуун)	15,048,700.00	12,619,255.00	2,429,445.00	
Шуудан холбоо	4,094,700.00	3,346,553.00	748,147.00	81.7
Дотоод албан томилолт	5,892,700.00	7,333,798.00	(1,441,098.00)	124.5
Гадаад томилолт /арга хэмжээ/	9,783,400.00	8,091,546.00	1,691,854.00	82.7
Ном хэвлэл авах	17,200,000.00	8,487,200.00	8,712,800.00	49.3
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	773,200.00	759,860.00	13,340.00	98.3
Урсгал засвар	766,000.00	233,610.00	532,390.00	30.5
Төлбөр хураамж болон бусад зардал	1,464,000.00	568,882.00	895,118.00	38.9
Гадаад зочны зардал	184,000.00	183,376.00	624.00	99.7
Байрны түрээсийн зардал	16,418,700.00	11,700,320.00	4,718,380.00	71.3
Түүх соёлын дурсгалт зүйл хамгаалах зардал	8,725,000.00		8,725,000.00	0.0
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс	14,100,000.00	13,800,000.00	300,000.00	97.9
ТӨГАҮ (Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс \	14,100,000.00	13,800,000.00	300,000.00	97.9
Татаас ба урсгал шилжүүлэг	587,648,700.00	396,819,392.00	190,829,308.00	67.5
Өрх гэрт олгох шилжүүлэг	587,648,700.00	396,819,392.00	190,829,308.00	67.5
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	55,545,200.00	53,569,860.00	1,975,340.00	96.4
Хэлмэгдэгсэд, тэдний ар гэрт олгох тэтгэмж	79,800,000.00	64,361,782.00	15,438,218.00	80.7
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,202,500.00	909,250.00	293,250.00	75.6
Хүн амын тодорхой бүлэгт үзүүлэх дэмжлэг	451,101,000.00	277,978,500.00	173,122,500.00	61.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	916,858,200.00	678,177,361.00	238,680,839.00	
Төсвөөс санхүүжих	916,858,200.00	678,177,361.00	238,680,839.00	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	1.00	1.00	50.0
АЖИЛЛАГСАД БҮГД	18.00	16.00	2.00	88.9
Удирдах ажилтан	2.00	1.00	1.00	50.0
Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-	100.0
Үйлчлэх ажилтан	3.00	1.00	2.00	33.3
Гэрээт ажилтан	2.00	2.00	-	100.0